

**"Монноос"ХК-ийн 2023 оны
үйл ажиллагааны тайлан**

"Монноос"ХК нь 2023 онд үндсэн үйл ажиллагаа явуулаагүй болно.

1. "Монноос"ХК-ийн үйл ажиллагаа зогссонаос хойш 20 гаруй жил тус компанийн үл хөдлөх хөрөнгө болон газрын төлбөр, өмнө нь авсан зээлийн хүү гэх мэт нь үйл ажиллагаа зогссонаос үл хамаарч байнга өсөн нэмэгдэж байсан зардлуудыг хамтран ажилладаг компаниудаас авсан дэмжлэгийн хүүгээр төлж ирснийг өмнөх хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнаж байсан билээ.
2. "Монноос"ХК-ийн үл хөдлөх хөрөнго, барилга байгууламж, тоног төхөөрөмж, газар доорхи болон ил инженерийн шугам сүлжээнүүдийн механик болон маралын элэгдэл нь дээрхи хөрөнгийг ямар ч үнэ цэнэгүй хог хаягдал болохоос өмнө нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас аль болох өндөр үнэ хүргэж борлуулах зөв шийдвэр гаргасан гэж үзэж байгаа болно. Ковидоос шалтгаалж дэлхий болон Монгол улсын эдийн засаг хямарч байсан нөхцөлд "Монноос"ХК-ийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулах баг комисс нь тухайн үедээ хэдийгээр өөрт нь эрсдэлтэй ч гэсэн хамгийн өндөр үнийн санал өгсон "Шунхлай Групп"-ийг сонгон гэрээ байгуулан хөрөнгө худалдан борлуулах үйл ажиллагааг зохион байгуулсан болно.
3. 2023 онд "Монноос"ХК-ийн хөрөнгийг худалдан борлуулсаны орлого 14,736,7сая₮ орж ирсэн бөгөөд үүнээс 8,350,0сая₮-ийг гэрээний дагуу "Ариг гал"ХК-д зээлсэн бөгөөд 3,1тэрбум₮-ийг татварт төлсөн болно. "Шунхлай Групп"-тэй байгуулсан гэрээний дагуу өнөөдрийн байдлаар 29,3тэрбум төгрөг төлөгдсөн байгаа бөгөөд 2024 онд 9,8тэрбум төгрөг төлөгдж дуусна.
4. "Монноос"ХК-ийн ТҮЗ-ийн хурлын / 2022 оны 11-р сарын 1-ний өдрийн "Их хэмжээний хэлцэл хийх" зөвшөөрөл олгох тухай 05/22 тоот тогтоолын дагуу "Монноос"ХК-ийг дэмжиж өөрийн хамаг мөнгөө шавхаж тус компанийг санхүүжүүлсэн төдийгүй 4,3тэрбум төгрөгийг өөрт хохиролтой ч гэсэн хүүгийн зөрүүний алдагдлыг хүлээж зээл олж өгч байсан. "Ариг гал"ХК-иас үзүүлсэн зээлийн эх үүсвэрээр "Монноос"ХК нь үл хөдлөх хөрөнгө болон газрын татвар, бусад орлогоос давсан зардлыг санхүүжүүлснээр өнөөдөр үл хөдлөх хөрөнгийн бүрэн бүтэн байдал, газар эзэмших эрхээ хадгалж үлдсэн тул "Монноос"ХК нь "Ариг гал"ХК-д үндэсний ноолуурын салбарын үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд дээрхи тогтоолд тэмдэглэсэн үндэслэлээр "Монноос"ХК-ийн хөрөнгө худалдсаны орлогоос өр төлбөрийг нь төлөөд үлдсэн үлдэгдлээс 20,0тэрбум төгрөг хүртэл хэмжээний зээлийг "Ариг гал"ХК-ийн ноолуур түүхий эд бэлтгэх эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийн зориулалтаар зээлдүүлсэн болно. "Монноос"ХК болон "Ариг гал"ХК-ийн хооронд байгуулсан "Санамж бичиг"-ийн хүрээнд "Монноос"ХК нь "Ариг гал"ХК-ийн үзүүлж байсан дээрхи дэмжлэгт хариу барьж зээлийн хүүг харьцангуй багаар олгохоор шийдвэрлэсэн бөгөөд "Монноос"ХК-иас

зээл төлөхийг шаардсан тохиолдолд "Ариг гал"ХК-ны зээлийг З сарын дотор эргэн төлөлтийн график харгалзахгүйгээр төлөхөөр тохиролцсон болно.

5. Дээрхи санамжийн хүрээнд "Монноос"ХК-иас орон нутагт ноос угаах үйлдвэрлэлийг сэргээх бусад чиглэлээр ажиллах шинэ бизнесийн эрэл хайгуул, судалгаа, төслийн ажилд "Ариг гал"ХК нь өөрийн мэргэжлийн инженер техникийн ажилтанууд, зөвлөхүүдийг татан оролцуулж ажиллуулж байгаа болно. Энэхүү судалгааны явцад сонгогдсон шинээр эхлүүлэх бизнест хоёр тал хамтарч ажиллана.
6. Компанийн хувьцааны үнийг хараат бус үнэлгээний байгууллагаар хийлгэж байгаа болно.

Гүйцэтгэх захирал  X.Эрдэнэбаяр

